**МОНГОЛ УЛС**
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 19 өдөр    Дугаар А/303    Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйл 30.2, 38 дугаар зүйл 38.1, 38.4 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэрт (Бага тойруу-4-424 тоот) байршилтай 234 м.кв (0,02 га) орон сууцны зориулалттай газрын эзэмшигч иргэн Доржсүрэнгийн Бат-Очир (ЗЕ:61122511) нь 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдөр нас барсан. Иймд хүү Бат-Очирын Энхбаяр (ЗК:05232415)-т зориулалтаар шилжүүлж 14 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (С.Бат-Оргил) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/109 тоот захирамжийн иргэн Д.Бат-Очир-т холбогдох хэсэг мөн газар эзэмших 000051255 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА    Ц.МӨНХБАТ